

# ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шаардлага хангаагүй төсөл, хөтөлбөрийг төлөвлөн, санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

**Аудитын код: ОРА-2024/18-13-ШТА-ГА**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: [narmandakhts@audit.gov.mn](mailto:narmandakhts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: В.Жавзмаа  
Утас: 70350757 Цахим хаяг: [javzmaav@audit.gov.mn](mailto:javzmaav@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн  
Утас: 70357955 Цахим хаяг: [orgilmurung@audit.gov.mn](mailto:orgilmurung@audit.gov.mn)  
Аудитор: Б.Бямбатогтох  
Утас: 70357955 Цахим хаяг: [byambatogtokhb@audit.gov.mn](mailto:byambatogtokhb@audit.gov.mn)  
Аудитор: Ж.Наранчимэг  
Утас: 70359806 Цахим хаяг: [naranchimegj@audit.gov.mn](mailto:naranchimegj@audit.gov.mn)  
Аудитор: Ц.Одгэрэл  
Утас: 70357955 Цахим хаяг: [odgerelts@audit.gov.mn](mailto:odgerelts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн тайлбар .....	2
Хүснэгтийн товьёг .....	2
Дүрслэлийн товьёг .....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	6
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүйгээс 15 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зарим ТАХ-ний санхүүжилтийг илүү олгож, үргүй зардал гаргасан байна.....	7
1.1.Хөрөнгөд бүртгэх боломжгүй урсгал зардалд төсвийн 24.4 хувийг зарцуулахаар төлөвлөж, 274 төсөл, хөтөлбөр нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй байна. ....	7
1.2. Бүрэн дуусаагүй ТАХ-ний төсвийг шилжих үлдэгдлээр баталж, дуусгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.....	9
1.3. Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу шалгаруулаагүй, холбогдох байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.....	10
1.4. ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохдоо хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс 8.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгож, үргүй зардал гаргасан байна.....	13
БҮЛЭГ 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлэх гэрээний хариуцлага тооцдоггүйгээс ТАХ удааширч, захиалагчийн хяналт хангалтгүй байна. ....	15
2.1. Төлөвлөсөн хугацааг сунгасан гүйцэтгэгчтэй гэрээний хариуцлага тооцдоггүйгээс дуусаагүй ТАХ байсаар байна.....	15
2.2. ТАХ-нд хэрэгжүүлэх захиалагчийн хяналтыг эрс сайжруулж, хариуцлага тооцох хэрэгтэй байна.....	17
2.3. Төсөл, хөтөлбөрийн зардал нь хөрөнгийн бус шинж чанартай тул зардлаар тайлагнасан байна. ....	19
БҮЛЭГ 3. Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг аймгийн хэмжээнд нэгтгэж тооцдоггүй байна. ....	19
3.1. Хэрэгжсэн ТАХ-ний 98 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. ....	19
3.2 Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг аймгийн хэмжээнд нэгтгэж тооцдоггүй байна.....	19
АУДИТЫН ДҮГНЭЛТ: .....	20
ЗӨВЛӨМЖ:.....	21
Холбогдох байгууллагын санал:.....	23
Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар: .....	26

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗС	Авто замын сан
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БХС	Байгаль хамгаалах сан
ГТН	Гэрээний тусгай нөхцөл
ДТС ОНӨХК	Дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит хувьцаат компани
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨХ	Тендерийн өгөгдлийн хүснэгт
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УДДТ	Ус, дулаан дамжуулах төв
УДХТ	Ус, дулаан хуваарилах төв
ХА	Харьцуулалтын арга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХББЗА ОНӨААТҮГ	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЦНБГ	Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ШХА	Шууд худалдан авалт

## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ОНХО баталсан ТАХ	6
Хүснэгт 2	Төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ	8
Хүснэгт 3	Тайлагнасан төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	11
Хүснэгт 4	Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүн	11

Хүснэгт 5	Санхүүжилт	13
Хүснэгт 6	ТАХ-ний хэрэгжилт	15
Хүснэгт 7	Бүрэн дуусаагүй ТАХ	15-16
Хүснэгт 8	ТАХ-ний гүйцэтгэл, чанар	17-18

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ТАХ-ний төлөвлөлт /нэр төрлөөр/	7
Хүснэгт 2	Төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт /тоо, сая төгрөгөөр/	9
Хүснэгт 3	ХАА-тай холбоотой гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал	12

<p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв"-ийн дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p><b>Аудитын зорилт</b></p>	<p>Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх,</li> <li>• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх,</li> <li>• Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.</li> </ul>
<p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>	<p>Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ зэрэг</p>

## **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын явцад гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлт,  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль  
Төсвийн тухай хууль,  
Төрийн хэмнэлтийн тухай хууль,  
Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,  
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,  
Барилгын тухай хууль,  
Эрчим хүчний тухай хууль,  
Авто замын тухай хууль,  
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,  
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,  
“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,  
Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,  
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,  
Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,  
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,  
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө,  
Засгийн газрын 2021 оны 160, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,  
Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,  
Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,  
Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,  
Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,  
Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд, Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд  
Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, Г.Оргилмөрөн, аудитор Б.Бямбатогтох, Ц.Одгэрэл, Ж.Наранчимэг нар 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

**Аудит хийхэд  
учирсан хүндрэл  
бэрхшээл**

Үүсээгүй болно.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орхон аймгийн 2023 оны төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/09 дүгээр тогтоолоор баталж, 2023 онд 1 удаа төсөвт зохицуулалт хийж, 1 удаа тодотгон баталсан байна.

Орхон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 63,392.5 сая төгрөгийн 69, шинээр эхлэх 50,738.7 сая төгрөгийн 369, нийт 439 ТАХ баталсан ба 434 ТАХ-г хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөжээ.

Төрөл	Хүснэгт 1			Баталсан ТАХ			Нийт		
	2022.12.02 нд баталсан			Тодотгосон					
	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
<b>Шилжих</b>	64	62,591.7	28,601.9	5	800.8	243.7	69	63,392.5	28,845.6
<b>Шинэ</b>	347	48,948.0	45,461.1	23	1,790.8	1,696.7	370	50,728.7	47,157.8
<b>Нийт</b>	411	111,539.7	74,063.0	28	2,591.6	1,940.4	439	114,131.2	76,003.4

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны батлагдсан төсөв

Эдгээр ТАХ-ний гүйцэтгэлийг 46,576.2 сая төгрөгөөр санхүүжүүлснээс, 6 ТАХ-ний худалдан авах ажиллагаа зарласан, 8 ТАХ-ний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, 1 ТАХ огт хэрэгжээгүй, 394 нь бүрэн дуусаж, 5 нь 2024 онд үргэлжлэн хэрэгжиж, 25 нь захиалагч болон гүйцэтгэгчээс шалтгаалан дуусаагүй байна.

Худалдан авах ажиллагаагаар 154 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг ОНӨГ зохион байгуулахаас техникийн тодорхойлолт, зураг төсөв ирээгүй 5, амжилтгүй болсон 4, зарласан 6, нийт 15 ТАХ-г шалгаруулаагүй, 139 ТАХ-ний худалдан авах ажиллагааг шалгаруулсан байна.

ТАХ-ний гүйцэтгэлийг холбогдох байгууллага хянасны дагуу санхүүжүүлж, 877.6 сая төгрөгийг орон нутгийн барьцааны дансанд, 1,451.5 сая төгрөгийг хяналтын зардлын дансанд төвлөрүүлсэн байна.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр эхлэх 1,772.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 1 ТАХ хэрэгжээгүй, 12 ТАХ-г 1,403.0 сая төгрөгөөр санхүүжүүлж, он дамжин хэрэгжих ТАХ үлдээгүй, 92.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орхон аймгийн Жаргалант сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр эхлэх 4,540.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 29 ТАХ-ний 3,793.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг санхүүжүүлж, 28 ТАХ бүрэн дуусаж, 1 ТАХ он дамжин хэрэгжихээр болж, 96.5 хувийн гүйцэтгэлтэй байна.


БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын ТАХ-ний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулаагүйгээс 15 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зарим ТАХ-ний санхүүжилтийг илүү олгож, үргүй зардал гаргасан байна.

1.1. Хөрөнгө бүртгэх боломжгүй урсгал зардалд төсвийн 24.4 хувийг зарцуулахаар төлөвлөж, 274 төсөл, хөтөлбөр нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтод нийцүүлжээ.

“Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөсөн байна.

2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 410 ТАХ-ний 48 буюу 11.7 хувь нь барилга байгууламж, 32 буюу 7.8 хувь нь барилга, их засварт, 52 буюу 12.7 хувь нь тоног төхөөрөмж, 4 буюу 1.0 хувь нь зөвлөх үйлчилгээ, 274 буюу 66.8 хувь нь зураг төсөв, зөвлөх үйлчилгээнд төлөвлөсөн байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:



Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны батлагдсан төсөв

Орхон аймгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төсвийн тухай хуулийн 14.2.4<sup>1</sup>-т заасны дагуу төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулсан байна.

Эдгээрээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй дараах ТАХ-г баталсан байна. Тухайлбал:

<sup>1</sup> 14.2.4-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”



1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-г ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг олон нийтээс аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6.5.5<sup>2</sup>-т заасантай нийцэхгүй байна.

2. ТАХ батлахаас өмнө зураг, төсөв, ТЭЗҮ хийж, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй 1,773.3 сая төгрөгийн 8 ТАХ байна.

- Уурхайчин багт Тамир зочид буудлын урдах УДХТ-ийг инженерийн шугам сүлжээнд холбох / дулаан механик /
- Уртын гол багт ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил
- Уурхайчин багт Тамир зочид буудлын урд УДХТөв байгуулах
- Зэвсэгт хүчний 186 дугаар ангийг түшиглэн буудлагын талбай байгуулах
- Найрамдал өндөрлөгийн шат болон тойрсон хэсгийн бэхэлгээний хананд засвар хийх
- Баянцагаан баг ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /А хэсэг/
- Баянцагаан баг ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /Б хэсэг/
- "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгын зураг төсөл боловсруулах

3. Баталсан ТАХ-ний эдийн засгийн үр ашгийн тооцоо, судалгаа хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын дүгнэлтийг огт гаргаагүй байна.

4. Өмнөх оны шилжих 8 ТАХ-ний төсөв өртгийг нэмэгдүүлж баталсан ба нэмэгдсэн төсөв магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна. Үүнд:


№	Хүснэгт 2 ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ Аймгийн ИТХ-аар баталсан төсөвт өртөг		
		2022 он	2023 он	Зөрүү
		1	Уртын гол багт баригдах 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил	10,000.0
2	Аймгийн ИТХ-ын заалны болон "Нэг цонх"-ны үйлчилгээний байрны өргөтгөл	3,200.0	4,302.0	1,102.0
3	Оюут баг, "Ачит" худалдааны төвөөс 2-40А байрны урдуур А1001 замтай холбох авто зам	585.0	928.6	343.6
4	Захиргааны 4-р байрны зүүн талын авто замын уулзварыг өргөтгөх	915.0	1,026.4	111.4
5	Номын өргөө бүхий цогцолбор барилга	4,166.0	4,655.9	489.9
6	Танил зах орчмын авто замын сүлжээг холбох хатуу хучилттай зам /2.29км/ хийх	2,977.0	4,338.7	1,361.7
7	11-р хорооллын Г хэсгийн авто замыг Уурхайчин хорооллын авто замтай холбох хатуу хучилттай зам /0.31км/ хийх	405.0	447.3	42.3
8	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах ажлын хүрээнд Цагаанчулуут багийн 49-53-р гудамжинд УДДТөв барих	623.6	1,469.8	846.2
<b>ДҮН</b>		<b>22,871.6</b>	<b>44,577.0</b>	<b>21,705.4</b>

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны батлагдсан төсөв

<sup>2</sup> 6.5.5-д "хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх"

5. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 238, 2 сумын хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 37, нийт 274 төсөл, хөтөлбөр нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, Төсвийн тухай хуулийн 4.1.24<sup>3</sup>-т заасантай нийцэхгүй урсгал зардалд 19,322.8 сая төгрөг баталсан байна.

Дүрслэл 2 Төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт /тоо, сая.төгрөгөөр/



Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны батлагдсан төсөв

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж буй бага өртөг бүхий болон урсгал зардлаар санхүүжүүлэх зардлууд батлахгүйгээр тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай бүтээн байгуулалтын ажлуудад төсөвлөж, батлах шаардлагатай байна.

1.2. Бүрэн дуусаагүй ТАХ-ний төсвийг шилжих үлдэгдлээр баталж, дуусгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

2020 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар баталсан 3 ТАХ одоо болтол дуусаагүй байтал тухайн ТАХ-г бүрэн дуусгах арга хэмжээ авахгүй, шилжих үлдэгдлээр баталсаар байна. Тухайлбал:

- Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил - гүйцэтгэл 83%, гэрээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгасан, санхүүжилтийг 90% олгосны дараа УДДТ, ХТП тоног төхөөрөмжийн угсралт эхлэхээр болсон байна.



<sup>3</sup> 4.1.24-д “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

- Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил Багц-2 Авто замын ажил -гүйцэтгэл 38% бөгөөд гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл сунгасан байна.



- Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажил /хүрээлэнгийн тоглоом/ - Гүйцэтгэгч Сокол ХХК-тай 2020 оны 06 дугаар сарын 16-нд түлхүүр гардуулах нөхцөлтэй ТГ-02/20 гэрээ байгуулж, НГ-07/22 нэмэлт гэрээ хийж, 2023 оны 07 дугаар сарын 01-нд дуусахаар байжээ.



Эдгээр ТАХ-г гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээг авч, дуусгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

ТАХ-ний 2023 онд санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулахад хугацаандаа хэрэгжих боломжит байдалд уялдуулсан байна.

ТАХ-г зураг төсөлгүй, түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулснаар ТАХ бүрэн хэрэгжихгүй байх, удаашрах, удааширснаар хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдах, төсөвт өртөг анх төлөвлөснөөс нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

1.3. Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу шалгаруулаагүй, холбогдох байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Орхон аймгийн ХАА-ны төлөвлөгөөг хуулийн хугацаанд эрх бүхий этгээдээр батлуулан, нийтэд ил тод мэдээлж, холбогдох байгууллагад хүргүүлж, тодотгол орсон тухай бүр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд төлөвлөгөөг шинэчилж, ХАА-г зохион байгуулсан байна.

Орхон аймгийн 2023 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг 13 удаа тодотгож, 2023.12.14-ний өдөр баталгаажуулсан ерөнхий төлөвлөгөөгөөр

57,292.2 сая төгрөгийн 413 ТАХ-ний 441 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж, дараах байдлаар тайлагнасан байна.

*Хүснэгт 3 Тайлагнасан төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам*

Д/д	Захиалагчийн нэр	Тендер шалгаруулах ТАХ-ний тоо	Худалдан авах БАҮ-ний тоо	Төсөвт өртөг /сая төгрөг/	Худалдан авах ажиллагаанд баримталсан журам <sup>4</sup>				
					НТШ	ХА	ШХА	Бусад	Нийт
1	Орхон аймгийн Засаг дарга	174	188	38,151.1	89	65	20	14	188
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	82	83	3,653.9	4	35	40	4	83
3	Жаргалант сумын ЗДТГ	55	56	10,983.3	8	12	35	1	56
4	Хот тохижуулах газар	11	12	1,639.7	3	4	5	0	12
5	ЦНБГ	2	2	120.3		2		0	2
6	Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	89	100	2,743.9	11	8	81	0	100
<b>Нийт дүн</b>		<b>413</b>	<b>441</b>	<b>57,292.2</b>	<b>115</b>	<b>126</b>	<b>181</b>	<b>19</b>	<b>441</b>

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан

Зохион байгуулсан 57,292.2 сая төгрөгийн 441 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны үр дүнгээр 53,170.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 425 бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэхээр 232 иргэн, аж ахуй нэгжийг шалгаруулж 50,897.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

*Хүснэгт 4 Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны үр дүн*

Д/д	Захиалагч байгууллагын нэр	Гүйцэтгэгч шалгарсан			Амжилтгүй болсон	
		Төсөвт өртөг /сая.төгрөг/	Тоо	Гэрээний дүн	Төсөвт өртөг /сая.төгрөг/	Тоо
1	Орхон аймгийн Засаг дарга	34,179.2	174	32,701.1	3,971.9	14
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	3,653.9	83	3,501.7		
3	Жаргалант сумын ЗДТГ	10,983.3	56	10,635.2		
4	Хот тохижуулах газар	1,639.7	12	1,571.2		
5	ЦНБГ	120.3	2	111.6		
6	Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК	2,594.6	98	2,376.6	149.3	2
<b>Нийт дүн</b>		<b>53,170.9</b>	<b>425</b>	<b>50,897.4</b>	<b>4,121.3</b>	<b>16</b>

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны худалдан авах ажиллагааны тайлан

Харин 4,121.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 бараа, ажил, үйлчилгээний ХАА амжилтгүй болсон, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна. Эдгээр нь зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй 1,280.8 сая төгрөгийн 5, тендерт шалгаруулалтад нэг ч компани оролцоогүй 630.6 сая төгрөгийн 6, шаардлага хангасан тендер ирээгүй болон амжилтгүй болсон, тендер зарласан 2,209.8 сая төгрөгийн 5 бараа, ажил, үйлчилгээ байна.

Зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой аймгийн хэмжээнд Сангийн яаманд 29, ШӨХТГ 1, нийт 30 гомдол гарсан байна.

<sup>4</sup> НТШ – Нээлттэй тендер шалгаруулалт, ХА – Харьцуулалтын арга, ШХА – Шууд худалдан авалт, Бусад – Хосолмол үнэлгээний арга, Бага үнийн арга, Гэрээ шууд байгуулах, Ерөнхий гэрээний журам, Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа зэрэг болно.

Орхон аймаг - 17	Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй, 6	А, 1	Жаргалант сум - 7	Баян-Өндөр сум - 6
Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 7			Гомдол татагдсан, 2	Б, 1
			Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй, 7	Үндэслэлтэй, 1

А:Гэрээ байгуулсны дараа гомдол гаргасан - 1,

Б:Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол гаргасан - 1.

Шийдвэр:Өрсөлдөөнийг хязгаарласан тул баримт бичигт өөрчлөлт оруулахыг даалгасан.

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тайлан

Дээрхээс харахад аймгийн худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан гомдлын 50 орчим хувь, сумдын худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан гомдлын 80-100 хувь захиалагчийн шийдвэр үндэслэлгүй гэж Сангийн яамнаас шийдвэрлэсэн байна.

Аудитаар аймгийн орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ДГТ 3-2-р байрны сантехникийг шинэчлэх - 80.0 сая төгрөг, ДГТ-ийн 2-3-р байрны шалны плаитаг солих – 100.0 сая төгрөгийн тус тус төсөвт өртөгтэй ажлын тендерийг зэрэг зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТӨХ-ийн ТШЗ 15.6.2-д шаардсан хүний нөөцийн шаардлагыг хангахгүй 1 оролцогчийг шалгаруулсан,
- Цагаанчулуут багт өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж худалдаж авах – 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барааны нийлүүлэгчийг сонгох ТББ-т баталгаат хугацааг ГТН-д 2 жил, ТӨХ-д 1 жил байхаар заасан, 400.0 сая төгрөгийн 58 нэр төрлийн бараанаас 5 нэр төрлийн 26.2 сая төгрөгийн бараа хүлээн авсан актыг баримтад үдэж архивласан байна.
- Аймгийн Засаг даргын 2023.01.05-ны өдрийн А/05 дугаар захирамжаар Жаргалант суманд эрх шилжсэн “Жаргалант сум 36-р тогич, бөөн бургасны ногооны талбайг хашаажуулах, хуучин хашааг засварлах” – 249.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан оролцогчийн мэдээллийг худалдан авах ажиллагааны тайланд алдаатай тусгасан.
- БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил – 212.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТӨХ-ийн ТШЗ 17.6.2.5-д шаардсан хүний нөөцийн шаардлагыг хангахгүй оролцогчийг шалгаруулсан.

- Даваат баг ундаргын 3-8-р гудамжийг жишиг гудамж болгох – 270.0 сая, Яргуйт багийн сайжруулсан зам хийх – 398.2 сая, Баянцагаан багийн сайжруулсан зам хийх – 248.5 сая, Рашаант багийн сайжруулсан зам хийх 399.7 сая, Ундаргын 3-р гудамж 17-р сургуулийн ар тал Соёлын төвийн дэргэд авто зогсоол хийх – 171.0 сая төгрөгийн тус тус төсөвт өртөгтэй ажлуудын тендерийг зэрэг зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТӨХ-ийн ТШЗ 17.6.4-д шаардсан одоо хийж байгаа, хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, дуусаагүй ажилтай бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолт, дуусаагүй ажлын гүйцэтгэл нь 70 хувиас багагүй байх ба инженер техникийн ажилтнууд нь давхцахгүй байх, давхацсан тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болох тухай шаардлагыг хангахгүй, өмнөх онуудын дуусаагүй 4 ажилтай, инженер техникийн ажилтнууд нь давхацсан, ТӨХ-ийн ТШЗ 17.2.1-д шаардсан харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өр, төлбөргүй талаарх тодорхойлолтыг тендер зарласан хугацаанаас хойш харилцагч банк бүрээс авч эх хувиас хуулбарлаж ирүүлэх шаардлагыг хангахгүй 1 оролцогчийг эдгээр бүх ажилд сонгон шалгаруулсан байна.

Дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байхад анхаарах, тендер шалгаруулалтын баримт бичгүүдийн иж бүрэн байдлыг хангах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

1.4. ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохдоо хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс 8.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгож, үргүй зардал гаргасан байна.

Нийт 481 ТАХ-ний 2023 оны санхүүжилт 82,316.6 сая төгрөг санхүүжүүлэхээс 57,098.4 сая төгрөг буюу 69.3%-ийг олгосон байна.

Хүснэгт 5	Санхүүжилт			сая.төгрөг	
	Баталсан дүн	Гүйцэтгэгчид олгосон	Хяналтын зардалд	Баталгаа 5%	Барьцаа дансанд
Аймгийн ОНХО	64,961.5	44,639.3	1,193.4	743.5	743.5
БХСан	4,108.3	1,436.8	28.4	43.6	43.6
АЗСан	2,138.4	2,021.9	49.2	64.6	64.6
Эрдэнэт сан	4,795.6	1,425.5	30.7	25.9	25.9
Баян-Өндөр сум	1,772.0	1,403.0	26.2	49.8	
Жаргалант сум	4,540.8	3,793.0	123.6		
<b>Нийт</b>	<b>82,316.6</b>	<b>54,719.5</b>	<b>1,451.5</b>	<b>927.4</b>	<b>877.6</b>

Эх сурвалж: Орхон аймгийн 2023 оны санхүүгийн тайлан, харилцах дансны хуулга

Төсөвт өртгийн бүрдэлд багтсан норм, нормативын санд төвлөрүүлэх зардлыг санхүүжилтээс суутгахгүй олгодог бөгөөд гүйцэтгэгч холбогдох норм, нормативын санд төлж, төлбөрийн баримтыг гүйцэтгэлийн баримтад хавсаргадаг байна.

Захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардлыг тухайн дансанд төвлөрүүлж, зохиогчийн хяналтын зардлыг гэрээ байгуулан, хянаж, актаар баталгаажуулан, олгож байна. Захиалагчийн хяналтын зардлыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хянан, олгожээ.

Аймгийн ИТХ-ын баталсан төсвийг төсвийн төлөвлөлтийн программд оруулахдаа 50.0 сая төгрөгөөр, олгосон санхүүжилтийг 99.2 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй оруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 37.1<sup>5</sup>, 37.1.1<sup>6</sup>, 37.1.7<sup>7</sup>-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлийн баталгаа, ажлын гүйцэтгэл, гэрээг үндэслэн олгосон эсэхийг тулгахад дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

1. "Цэцэрлэгийн барилга 150 ор /Орхон, Баян-Өндөр сум гадна тохижилт/ ТАХ-ний зураг төсөвт тусгасан 143.8 сая төгрөгийн ажил дутуу гүйцэтгэсэн байтал санхүүжилт олгосон тул дутуу гүйцэтгэсэн ажлыг дахин гүйцэтгүүлэх албан шаардлагыг Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүргүүлэв.
2. "Цэцэрлэгийн барилга 150 ор /Орхон, Баян-Өндөр сум гадна тохижилт/ ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохдоо 4.4 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон тул барьцааны данснаас суутгах албан шаардлагыг Баян-Өндөр сумын ЗДТГ-т хүргүүлэв.
3. Жаргалант сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар баталсан 5 төсөл, хөтөлбөрт санхүүжилт олгохдоо 3.9 сая төгрөгийг илүү зарцуулсан тул Жаргалант сумын ЗДТГ-т албан шаардлага хүргүүлэв.
4. Жаргалант сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, хөтөлбөрийн зардлаас 2.5 сая төгрөгийн спорт заалны онооны самбарын засварын зардал гаргасан тул Жаргалант сумын ЗДТГ-т зөвлөмж хүргүүлэв.
5. Жаргалант сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар баталсан төсөл, хөтөлбөрийн зардлаас баяр наадмын зардалд анхан шатны баримтгүй 1.9 сая төгрөгийг зарцуулсан тул Жаргалант сумын ЗДТГ-т төлбөрийн акт тогтоов.
6. Төрийн бус байгууллагуудад олгосон 3.2 сая төгрөгийн ажлын хөлс, шагнал урамшууллаас хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу суутгал хийгээгүй тул төлбөрийн акт тогтоов.
7. Төсвийн хөрөнгөөр 0.3 сая төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авсанд төлбөрийн акт тогтоов.
8. Томилолтоор ажилласан аймгийн Засаг даргын тамгын газрын албан хаагчдад хоолны зардал 0.2 сая төгрөг давхардуулан олгосонд төлбөрийн акт тогтоов.
9. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн төв ажиллуулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор 2023 онд батлагдсан төсвийг тайлант оны эцэст 2024 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр "Эрдэнэт академи" НҮТББ-тай 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 49/23 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулан 40.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон боловч өдийг хүртэл гэрээний үүргээ биелүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.
10. Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Хөрөнгө гаргах тухай" А/795 дугаар захирамжаар "Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээний зардлаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг гэрийн эргэлтэд шилжүүлэх, эрчимжүүлэх" төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн газар нь 15.0

<sup>5</sup> 37.1 Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ

<sup>6</sup> 37.1.1 Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих

<sup>7</sup> 37.1.7 төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах

сая төгрөгөөр шатахуун худалдан авч, 9.0 сая төгрөгийн шатахуун зарцуулаагүй, нөөцөлсөн байх тул төлбөрийн акт тогтоов.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдөр баталсан 278 дугаар тогтоолын 4.8.13<sup>8</sup>-д гэрээний урьдчилгааг 30%-аар олгохоор тусгасан байтал гэрээнд 50-80%-аар зааж, 1 ТАХ-ний урьдчилгааг 50%, 1 ТАХ-ний урьдчилгааг 80%, 1 ТАХ-ний урьдчилгааг 100%-аар тооцож олгосон тул гэрээг журамд нийцүүлж, хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2.** Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлэх гэрээний хариуцлага тооцдоггүйгээс ТАХ удааширч, захиалагчийн хяналт хангалтгүй байна.

2.1. Төлөвлөсөн хугацааг сунгасан гүйцэтгэгчтэй гэрээний хариуцлага тооцдоггүйгээс дуусаагүй ТАХ байсаар байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 481 ТАХ-ээс 6 ТАХ-ний худалдан авах ажиллагаа бүрэн дуусаагүй, 9 ТАХ амжилтгүй болсон, зураг төсөвгүй, 433 бүрэн дуусаж, 26 нь он дамжиж, 2 ТАХ огт хэрэгжээгүй, 5 нь гэрээний хугацаа дуусаагүй буюу 2024 онд хэрэгжиж дуусах бөгөөд нийт хөрөнгө оруулалт 90.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

ТАХ-г холбогдох зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу хэрэгжүүлсэн хэдий ч 40 ТАХ-ний гэрээний хугацааг сунгасан байна.

<i>Хүснэгт 6</i>		<i>ТАХ-ний хэрэгжилт</i>			
<b>ТАХ-ний ангилал</b>	<b>Нийт ТАХ тоо</b>	<b>Бүрэн хэрэгжсэн</b>	<b>Он дамжин хэрэгжих</b>	<b>ХАА зохион байгуулаагүй</b>	<b>Гүйцэтгэлийн хувь</b>
Барилга байгууламж	91	67	4	6	73.6%
Их засвар	38	32			84.2%
Тоног төхөөрөмж	62	55	1	4	88.7%
Зөвлөх үйлчилгээ	15	9		5	60.0%
Төсөл, хөтөлбөр	275	270		2	98.1%
<b>Нийт дүн</b>	<b>481</b>	<b>433</b>	<b>5</b>	<b>17</b>	<b>90.0%</b>

Эх сурвалж: ХББЗА ОНӨААТҮГ-ын хяналт хэрэгжүүлсэн тайлан, судалгаа

Хэрэгжилт дутуу 31 ТАХ-ний 5 нь он дамжин хэрэгжих буюу гэрээний хугацаа болоогүй, 26 нь бүрэн хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй 26 ТАХ-ний хувьд захиалагчаас шалтгаалсан 11, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан 12, комисс ажиллахад бэлэн болсон 3 ТАХ байна. Тухайлбал:

<i>Хүснэгт 7</i>		<i>Бүрэн дуусаагүй ТАХ</i>	
<b>№</b>	<b>Төсөл, арга хэмжээний нэр</b>	<b>Ажлын гүйцэтгэл /хувь/</b>	<b>Дуусаагүй шалтгаан</b>
1	Захиргааны 4-р байрны зүүн талын авто замын уулзварыг өргөтгөх /2022 он/	80	Гүйцэтгэгч байгууллагаас

<sup>8</sup> 4.8.13-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухай онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна"



2	Танил зах орчмын авто замын сүлжээг холбох хатуу хучилттай зам 2.29км /2022 он/	70	Гүйцэтгэгч байгууллагаас
3	Цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн хэсгийн хашаажуулах /2021 он/	85	Гүйцэтгэгч байгууллагаас
4	Уртын гол багт баригдах 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил /2021 он/	75	Гүйцэтгэгч байгууллагаас
5	11-р хорооллын 2х2000м3-н усан санг ашиглалтад оруулах үлдэгдэл санхүүжилт /2020 он/	95	Захиалагчаас
6	Эрдэнэ багийн усан санд өргөлтийн насос нэмж суурилуулах /2020 он/	90	Гүйцэтгэгч байгууллагаас
7	Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажил-хүрээлэнгийн тоглоом /2020 он/	10	Гүйцэтгэгч байгууллагаас
8	Эрдэнэт УС ДТС ОНӨХК-ийн захиргааны байр барих /2020 он/	80	Гүйцэтгэгч байгууллагаас
9	Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил /2020 он/	83	Захиалагчаас
10	Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил Багц-2 Авто замын ажил /2020 он/	38	Гүйцэтгэгч байгууллагаас
11	Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх ажлын зардал, багц-4 Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт /2020 он/	93	Гүйцэтгэгч байгууллагаас
12	Уртын гол багт худаг барих	95	Комисс ажиллана
13	Номын өргөө бүхий цогцолбор барилга	100	Комисс ажиллана
14	Нэг цонхны үйлчилгээний төвийг засварлах "Цахим төв" болгох /Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд/ төсөл, арга хэмжээний Багц-1: нэг цонхны үйлчилгээний төвийг засварлах	100	Комисс ажиллана
15	Баянцагаан багийн инженерийн шугам сүлжээний /гадна дулаан, ус хангамж, ариутгах татуурга/ хийх ажлын зураг төсөл боловсруулах зөвлөхийн гэрээ /2018 он/	80	Захиалагчаас
16	Батлагдсан гурван байршлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах	90	Захиалагчаас
17	Эрдэнэт хотын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангахаар төлөвлөж буй 35кВ-ын агаарын шугамын трасс зураглал, зураг төсөл боловсруулах	90	Захиалагчаас
18	Орхон аймаг, Баян-Өндөр сумын Оюут багийн 2а хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	0	Захиалагчаас
19	Яргуйт багийн авто замыг А1002 авто замтай холбох /299 метр/	80	Гүйцэтгэгч байгууллагаас
20	Найрамдал өндөрлөгийн шат болон тойрсон хэсгийн бэхэлгээний хананд засвар хийх 70	50	Гүйцэтгэгч байгууллагаас
21	Хөв цөөрмийн ажлыг дуусгах /Эрдэнэ баг, Бүрэнбүстийн овооны хажууд/	40	Гүйцэтгэгч байгууллага
22	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн амбулаторийн өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ	70	Захиалагчаас
23	Баян-Өндөр сумын Хүрэнбулаг баг Уурхайчин-1 хотхоны баруун талд баригдах амины болон цөөн давхар барилгын орон сууцны хотхон хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	80	Захиалагчаас
24	Аялал жуулчлалын цогцолборын зураг төсөл боловсруулах	95	Захиалагчаас
25	Эрдэнэтэд үйлдвэрлэв зураг төсөл боловсруулах	80	Захиалагчаас
26	Хөдөө аж ахуйн барилга байгууламж	80	Захиалагчаас

Эх сурвалж: ХББЗА ОНӨААТҮГ-ын хяналт хэрэгжүүлсэн тайлан, судалгаа

Дуусаагүй ТАХ нь техникийн нөхцөл олгох, зургийн даалгавар өөрчилсөн, худалдан авах ажиллагааг дахин зарласан зэрэг нь захиалагчаас шалтгаалсан бол гэрээний хугацааг баримтлаагүй, хариуцлагагүй байдал нь гүйцэтгэгчээс шалтгаалсан байна.

Иймд ТАХ-г гүйцэтгэх гэрээний хугацаанд дуусгахад анхаарч, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2. ТАХ-нд хэрэгжүүлэх захиалагчийн хяналтыг эрс сайжруулж, хариуцлага тооцох хэрэгтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжсэн ТАХ-нд Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ захиалагчийн тавих үе шатны явцын болон техникийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу барилгын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, холбогдох баримтаар баталгаажуулжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс 8 төсөл, арга хэмжээ чанаргүй гүйцэтгэсэн нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.19<sup>9</sup>, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 278 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.5<sup>10</sup>-т заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

Хүснэгт 8		ТАХ-ний гүйцэтгэл, чанар	
д/д	ТАХ-ний нэр	Гүйцэтгэгч байгууллага	Илэрсэн алдаа зөрчил
1	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зэст баг/	Талст билэг ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Гадна тохижилтын ажил дутуу,</li> <li>2. 4 давхрын паркет хөндийрсөн,</li> <li>3. Хаалганд суулт үүссэн,</li> <li>4. Зоорины давхрын шалыг давхар будаагүй,</li> <li>5. 1 давхрын хаалганы дээд хэсгийн шил хагарсан,</li> <li>6. Усны хаялгын шугамын дагуу ус гоожсон, гадна гарсан хэсэгт ус зайлуулах суваг хийгээгүй,</li> <li>7. Гадна авто зам чанаргүй хийсэн,</li> <li>8. Хууль зүйн туслалцааны төвийн үүдний хаалганы дээд хэсгийн шил хийгээгүй,</li> <li>9. Шатны хажуугийн шавар, эмульс чанаргүй хийсэн,</li> </ol>
2	Номын өргөө бүхий цогцолбор барилга	Шинжүү ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. 2 ширхэг давхар хаалга дутуу,</li> <li>2. Гадна тохижилтын ажил дутуу,</li> <li>3. Хаалганы цоож солих,</li> <li>4. Эко хавтан суулт өгсөн,</li> <li>5. Дээврээс ус гоожсон,</li> <li>6. Дээврийн шилэн хаалт хоорондоо зайтай,</li> </ol>

<sup>9</sup> 37.1.19-д “барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах”

<sup>10</sup> 4.4.1.5-д “Захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх”

3	Зэст багт спорт заал барих	Хөх тавилан ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Заалны шал завсар ихтэй, шахах шаардлагатай,</li> <li>2. Гадна фасад хуурсан,</li> <li>3. Усны хаялга байхгүй,</li> <li>4. 00-н өрөөний доторх засвар хийгдээгүй,</li> <li>5. 00-н өрөөний хаалтын гагнаас салсан</li> <li>6. Ханын будаг алаглуулж будсан,</li> <li>7. Гадна шатны цемент нурсан, плита хуулсан</li> <li>8. Барилгын хаяавч зааг гарсан,</li> <li>9. Хаалганы амлагаа муу,</li> <li>10. Сангийн пар шугамын хэсгийн будаагүй,</li> <li>11. Дээврээс ус гоожсон,</li> <li>12. Узелийн өрөө дотор засваргүй</li> </ol>
4	Унага цэцэрлэгийн фасад	Талст билэг ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Фасадын зарим хэсэг хагарсан,</li> <li>2. Цонхны усны хаялга буруу хийснээс анги руу ус орсон</li> </ol>
5	Уран эгшиг урлагийн төрөлжсөн сургуульд их засвар хийх	Сууц трейд ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Таазны эмульс хуурсан,</li> <li>2. Ханын эмульс халтартсан.</li> </ol>
6	Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт	Легато констракшн ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Тоглоомын суурийн шороо суулт өгсөн,</li> <li>2. Тоглоомын будаг хуурсан.</li> </ol>
7	Найрамдал өндөрлөг, Их шүтээн цогцолборын авто зогсоол, гэрэлтүүлэг, тохижилтыг сэргээн засварлах	Алист констракшн ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. Шатны холбоос хэсэг хагарсан,</li> </ol>
8	Хүрэнбулаг багт камержуулалт хийх	Аркосис ХХК	<ol style="list-style-type: none"> <li>1. 4-10 дугаар байр дээр суурилсан камерын дүрс жирэлзсэн,</li> </ol>

Эх сурвалж: Аудиторын ажлын баримт

Аудитаар 2023 онд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолттой тулган, ашиглалтыг шалгалаа. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцсэн эсэхийг тулгахад 3.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлээгүй байтал хөрөнгөд бүртгэн, хүлээн авсан акт үйлдэн, санхүүжилтийг бүрэн олгожээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.6<sup>11</sup>, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.10.1.4<sup>12</sup>, "Шинээр байгуулагдсан Уран эгшиг урлагийн төрөлжсөн сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил худалдаж авах гэрээ" /Багц:1-Компьютер, тоног төхөөрөмж ОРАОНӨГ/202312079 дугаар гэрээний

<sup>11</sup> 41.2.6-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"

<sup>12</sup> 4.10.1.4 -д "Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, энэ журмын 9 болон 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана"

2.2<sup>13</sup>-д заасантай нийцэхгүй тул тоног төхөөрөмжийг хүлээн авах албан шаардлага хүргүүлэв.

ТАХ-ний гүйцэтгэлд гарч буй зөрчлүүд нь захиалагч болон зохиогчийн хяналт үр дүн муутайгаас шалтгаалсан, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1<sup>14</sup>-д заасан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж, эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллаагүйтэй холбоотой байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын хяналтыг сайжруулж, тулган баталгаажуулахад зөрчил үүсгэсэн гүйцэтгэгчийн гэрээний үүргийг хангуулах зөвлөмжийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв.

2.3. Төсөл, хөтөлбөрийн зардал нь хөрөнгийн бус шинж чанартай тул зардлаар тайлагнасан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 163 ТАХ-г зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу улсын комиссын актаар хүлээн авч, Орон нутгийн өмчийн газар бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 270 төсөл, хөтөлбөрийн зардал нь хөрөнгийн бус зардлын шинж чанартай тул хөрөнгөд бүртгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4.1.24<sup>15</sup>-т заасантай нийцэхгүй байна.

Тухайн байгууллагуудын хөрөнгөд бүртгэлтэй хэдий ч зориулалт бусаар ашиглах, худалдан борлуулах, зорилтот хэрэглэгчийг үнэн зөв тодорхойлоогүйгээс төслийн үр дүнг бууруулах эрсдэл үүсгэж байна.

**БҮЛЭГ 3. Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг аймгийн хэмжээнд нэгтгэж тооцдоггүй байна.**

3.1. Хэрэгжсэн ТАХ-ний 98 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.

Бүрэн хэрэгжиж дууссан 163 ТАХ-ээс 160-ыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа ба үүнээс Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-д бүртгэлтэй 10,023.8 сая төгрөгийн УДДТ-ийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна. Тухайн УДДТ-ийн барилга, тоног төхөөрөмж бэлэн боловч цахилгааны тэжээл, хангах шугамын ажил хийгдээгүйгээс шалтгаалан ашиглаж эхлээгүй байна.

3.2 Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг аймгийн хэмжээнд нэгтгэж тооцдоггүй байна.

<sup>13</sup> 2.2 -д "Захиалагч барааг хүлээн авсны дараа актыг үндэслэн нийлүүлэгчид төлбөрийг 100 хувиар олгоно"

<sup>14</sup> 69.1 -д "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна"

<sup>15</sup> 4.1.24-д "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг"

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29<sup>1.1</sup><sup>16</sup>, 29<sup>1.2</sup><sup>17</sup>-д заасан шаардлагыг хангуулаагүй, ТАХ-ний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу үнэн зөв, бодитой тооцоолоогүй байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтын үр дүнг нэгтгэж, тооцдоггүй байна. Энэ нь ТАХ-ний үр дүн үнэлэх боломжгүйг илтгэж байна.

Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний ашиглалт, түүний үр өгөөж тооцох үнэлгээ хийх удирдамжийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухай бүр төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэхээр заасан хэдий ч 2023 онд аймгийн Засаг даргад ирүүлээгүй байна.

Аудитаар илэрсэн 21,308.5 сая төгрөгийн зөрчлөөс 14.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулах 195.3 сая төгрөгийн 7 албан шаардлага, 21,098.6 сая төгрөгийн 10 зөвлөмж хүргүүллээ.

#### АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Хөрөнгөд бүртгэх боломжгүй урсгал зардалд төсвийн 24.4 хувийг зарцуулахаар төлөвлөж, 274 төсөл, хөтөлбөр нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй байна.
- Бүрэн дуусаагүй ТАХ-ний төсвийг шилжих үлдэгдлээр баталж, дуусгах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
- Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу шалгаруулаагүй, холбогдох байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.
- ТАХ-ний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгохдоо хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс 8.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгож, үргүй зардал гаргасан байна.
- Төлөвлөсөн хугацааг сунгасан гүйцэтгэгчтэй гэрээний хариуцлага тооцдоггүйгээс дуусаагүй ТАХ байсаар байна.
- ТАХ-нд хэрэгжүүлэх захиалагчийн хяналтыг эрс сайжруулж, хариуцлага тооцох хэрэгтэй байна.
- Төсөл, хөтөлбөрийн зардал нь хөрөнгийн бус шинж чанартай тул зардлаар тайлагнасан байна.
- Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан боловч төсөл, хөтөлбөрийн зардлаас бэлтгэсэн хөрөнгийг бүртгээгүй байна.

---

<sup>16</sup> 291.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

<sup>17</sup> 291.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан бай

- Хэрэгжсэн ТАХ-ний 98 хувийг бүрэн хүчин чадлаар ашиглаж байна.
- Хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг аймгийн хэмжээнд нэгтгэж тооцдоггүй байна.

#### ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

#### Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 он хүртэл хүлээн авсан боловч зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглаж эхлэх хугацаа тодорхойгүй орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар шийдвэр гаргах.

#### Аймгийн Засаг даргад:

- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, үр дүнг тооцсон, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 он хүртэл хүлээн авсан боловч зориулалтын дагуу ашиглаагүй, ашиглаж эхлэх хугацаа тодорхойгүй орон нутгийн өмчид бүртгэлтэй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулах.

#### Баян-Өндөр, Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг батлах.

#### Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг даргад:

- Төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, үр дүнг тооцсон, төсөвт байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангуулж, төлөвлөсөн үр дүн тооцож, зориулалтын дагуу ашиглан үр нөлөөг сайжруулах.

#### Жаргалант сумын Засаг даргад:

- Болзошгүй аваарын зардлаас журамд нийцээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:

- Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын холбогдох заалтыг бүрэн тусгаж, гэрээний хугацаанд ТАХ-г дуусгахад анхаарч ажиллаж, холбогдох албан хаагчдын хариуцлагыг сайжруулах.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөх болон хэрэгжсэн ТАХ-ний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хангуулж, төлөвлөсөн үр дүн тооцож, нэгтгэн дүгнэх.

ХББЗА ОНӨААТҮГ-ын захиралд:

- Гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын холбогдох заалтыг бүрэн тусгаж, гэрээний хугацаанд ТАХ-г дуусгахад анхаарч ажиллаж, холбогдох албан хаагчдын хариуцлагыг сайжруулах.

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛС**  
**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 51033  
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621  
Цахим шуудан: info@erdeneet.mn

2024.05.24 № 01/10664  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

*В. Шавзмаа*  
*Аудитор*  
*М.Түмэнжаргал* 2/29

Санал хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа. Тус тайлангийн ТАХ батлахаас өмнө зураг төсөв хийж, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулаагүй ажлуудыг Баянцагаан багийн ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /А хэсэг/, Баянцагаан багийн ДЦСтанцын цагаан байрны айл өрхүүдийн ИШС-г засварлах /Б хэсэг/ ажил нь тухай жилийн төсвийн хүрээнд хэрэгжилт зохион байгуулалт аваагүй хөрөнгийг татаж хэмнэсэн, мөн "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгын зураг төсөл боловсруулах ТАХ нь зөвлөх үйлчилгээ буюу ажлын даалгавар боловсруулан зураг төсөв хийх ажил тул тайлангаас хасуулах саналтай байна.

Мөн өмнөх оны шилжих үлдэгдлээс төсөвт өртөгийг нэмэгдүүлсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан эсэх тодорхойгүй гэх /Магадлалын ерөнхий дүгнэлтийг хавсаргав/ дараах ажлуудыг мөн тайлангаас хасуулах саналтай байна.

Хавсралт.....хуудастай.

ЗАСАГ ДАРГА



М.ТҮМЭНЖАРГАЛ

0174022362





**ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут Баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025  
Утас: 70357965, факс: 70350965  
Цахим хаяг: www.bayanundur.mn  
Цахим шуудан: buzdtg@gmail.com

2024 05 27 № 03/780

Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Хөх тавилан” ХХК нь 150 ортой цэцэрлэгийн барилга барьж гүйцэтгэснийг мэргэжлийн байгууллага болох ХББЗА-ОНӨААТҮГ-ын инженерийн дүгнэлтээр хүлээн авсан учир албан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүйг үүгээр мэдэгдэж байна. Нотлох баримтыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт .... хуудастай.

ДАРГА



Ш ӨЛЗИЙБАЯР

В.Навзмааг  
Баримт, дайжсаг-  
нууцлалт  
6124030360 78.



**ОРХОН АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Жаргалант баг,  
Жаргалант сум, Орхон аймаг, 61010, Утас: 7039-7203  
Цахим хуудас: www.erdenet.mn

2024 о. 5. 22 № 01/528  
Танай 2024 о. 5. 21 -ны № 167 -Т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц НАРМАНДАХ ТАНАА**

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын  
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн  
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой тусгах санал  
байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

*Б.Бэмбэлэгтөг*

*Аудгетай*

*М.Б. 427*

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар:

Орхон аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Санал 1	Саналд тусгасан 3 ТАХ-г шалгасан ба 2024 оны төсөвт мөн дүнгээр тусгасан байх тул хэвээр үлдээсэн болно.
Санал 2	Төсөвт өртөг нэмэгдүүлсэн 8 ТАХ-ний “Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэл”-ийг үндэслэн саналыг хүлээн авч өөрчилсөн.

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

Санал 1	Нотлох баримтаар дэмжигдэж байгаа ба аудитын явцад баталгаажуулсан болно. Баян-Өндөр сумын ЗДТГ нь захиалагч байгууллага бөгөөд барилга, байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын бүрэлдэхүүнд тус байгууллагаас эрх бүхий албан тушаалтан ажилласан байх тул саналыг хүлээн авах боломжгүй болно.
---------	--